

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР



ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ-2023 он

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	I
Зургийн жагсаалт	II
Хүснэгтийн жагсаалт.....	v
Удиртгал	1
Судалгааны үндэслэл	1
Судалгааны арга зүй	2
Нэг. ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХУУЛЬД ТУСГАЙЛАН ЗААСАН БОЛОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ.....	4
1.1. Гадаадын иргэн харьяатын газрын нийтлэг чиг үүрэг	6
1.1.1. Мэдээллийн ил тод байдал, хүртээмж	7
1.1.2. Иргэний шаардах эрхийн баталгаа: өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байдал	17
1.1.3. Үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжид үйлчлүүлэгчдийн өгсөн үнэлгээ.....	18
Хоёр. ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА	31
2.1. Алба хаагчийн ажиллах нөхцөл, нийгэм, эдийн засгийн баталгаа	31
2.2. ГИХГ-аас үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм.....	31
ДҮГНЭЛТ	35
ЗӨВЛӨМЖ	40

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХЗДХ-ийн Сайд	Хууль зүй, дотоод хэргийн Сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХШН боомт	Хилийн шалган нэвтрүүлэх боомт



УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Хууль зүй, дотоод хэргийн яам, харьяа агентлаг, байгууллага нь чиг үүргийн дагуу иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлэхдээ Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан хүний эрх, шударга ёс, тэгш байдлыг ханган ажиллах үүрэг хүлээдэг.

Салбарын байгууллагын үйлчилгээний талаар иргэд, байгууллагын сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх, тодруулбал Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллага иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээ тэгш, хүртээмжтэй, чанартай, хүний эрхийг хүндэтгэсэн, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэд, байгууллагын сэтгэл ханамж, хандлагыг үнэлэх нь чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баталж, дээрх байгууллагуудаас тухайн жилд хэрэгжүүлсэн зорилтуудын биелэлт, үр нөлөөний талаар хэрэглэгчийн үнэлгээг жил бүр хийн ажиллахаар тусгажээ. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэг болгосны дагуу тус яамны төрийн нарийн бичгийн даргын баталсан Хууль зүй, дотоод хэргийн яам түүний харьяа агентлаг, байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлдэг үйлчилгээнд хөндлөнгийн судалгаа /хяналт үнэлгээ/ хийлгэх ажлын удирдамжаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Гадаадын иргэн, харьяатын газрын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээнд хэрэглэгчийн үнэлгээ судалгааг гүйцэтгэлээ.

Зорилго, зорилт

Гадаадын иргэн, харьяатын газрын хуулиар олгогдсон чиг үүргийн дагуу иргэн, гадаадын иргэн. аж ахуй нэгж байгууллагад үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийхэд чиглэнэ. Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

1. 2023 оны байдлаар Гадаадын иргэн, харьяатын газарт ирүүлсэн санал, өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийх;
2. Гадаадын иргэн, харьяатын газрын Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд төрөөс



- анхаарах шаардлагатай асуудал болон зайлшгүй өөрчлөлт хийх эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх
3. Хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжийн бодит байдлыг үйлчилгээг хүртэгч иргэд, байгууллагын санаа бодол, сэтгэл ханамжид тулгуурлан хэрэглэгчийн үнэлгээний арга зүйгээр тандан судлах;
 4. Хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйл ажиллагаа, үйлчилгээнд цаашид анхаарах асуудал, сайжруулах арга замыг тодорхойлох зэрэг болно.

Судалгааны арга зүй

Хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, түргэн, шуурхай байдлыг үнэлэхдээ асуулга, ярилцлагын аргыг хэрэглэв. Тодруулбал, Гадаадын иргэн, харьяатын газраар үйлчлүүлэгч иргэн, байгууллагаас асуулгын аргаар, Гадаадын иргэн харьяатын газар болон тус байгууллагатай хамтарч ажилладаг байгууллагын төлөөллөөс ганцаарчилсан ярилцлагын аргаар тоон болон чанарын мэдээлэл цуглуулж нэгтгэн дүгнэлээ.

1. Баримт бичиг боловсруулалтын арга. Гадаадын иргэн, харьяатын газраар хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөж буй хэм хэмжээний акт, тэдгээрийн хэрэгжилт, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйлчлүүлэгчид чиглэсэн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг байгууллагын тайлан мэдээтэй харьцуулан үнэлэх зорилгоор тус аргыг ашигласан болно.

2. Асуулгын арга. Урьдчилан боловсруулсан асуулгын хуудсаар Гадаадын иргэн харьяатын газраар үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээдийг хамруулан тус байгууллагын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмж болон үйл ажиллагаанд анхаарах асуудал, саналуудыг тодорхойлсон тоон мэдээллийг цуглууллаа. Асуулга судалгаанд Улаанбаатар хотод байрлах ГИХГ болон Хөшигийн хөндийн агаарын замын Буянт-Ухаа олон нисэх буудлаар үйлчлүүлсэн нийт 191 иргэн, 22 ААНБ-ыг хамруулав. Хүснэгт 1.1-т асуулга судалгааны түүврийн мэдээллийг харууллаа.

3. Ганцаарчилсан ярилцлагын арга. Гадаадын иргэн, харьяатын газрын ажилтан, алба хаагч, тус байгууллагатай хамтран ажилладаг төрийн байгууллагын төлөөллийг хамруулсан ярилцлагыг зохион байгууллаа Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлын төлөөллийг оролцуулан үнэлгээний зорилгод чиглэсэн мэдээллийг цуглууллаа. Хүснэгт 1-т ганцаарчилсан ярилцлагад хамруулах оролцогч талуудын тоон мэдээллийг үзүүлэв.

Хамрах хүрээ, түүвэрлэлт. Хэрэглэгчийн үнэлгээ судалгаанд Гадаадын иргэн



харьяатын газраар үйлчлүүлэгч нийт 191 иргэн, 22 ААНБ-ын төлөөллийг санамсаргүй түүвэрлэлтийн арга техникээр хамруулсан ба судалгаанд хэрэглэсэн арга тус бүрээр нь дараах түүвэрлэлтийн хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Асуулга судалгаанд хамрагдсан ГИХГ-аар үйлчлүүлэгч иргэн (n=191) ба зөвшөөрөл авсан ААНБ-ын (n=22) тоо

Хүснэгт-1

Судалгааны талбар	Иргэн	Байгууллага
Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал	106	8
Бүгд	106	8

Хүснэгт 2. Ганцаарчилсан ярилцлагад хамруулах төрийн байгууллага болон ГИХГ-ын холбогдох мэргэжилтний тоо (n=54)

Хүснэгт-2

№	Ярилцлага хийх субъект	Ганцаарчилсан ярилцлагын тоо
1	Үйлчлүүлэгч иргэн	2
2	Үйлчлүүлэгч /компанийн төлөөлөл/	2
3	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлын төлөөлөл	4
4	ГИХГ, ХЗДХЯ	5
7	Нийт	13

Нэг. ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУДАД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

1.1.Гадаадын иргэн, харьяатын хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд томоохон ажлуудыг дэвшүүлэн хийгдсэн ажлыг жилийн эцсийн байдлаар үнэлэхэд:

Хүснэгт-3

ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД	Үүнээс (хувиар)		Хувь
	100	90	
1.Гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах хүрээнд	1	-	100%
2.Гадаадын иргэний бүртгэл, хяналтыг эрхлэх хүрээнд	-	1	90%
3.Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах хүрээнд:	1	-	100%
4.Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, холбогдох ажиллагааг зохион байгуулах хүрээнд:	1	-	100%
5.Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай гадаадын иргэний хүсэлтийг шийдвэрлэх, үрчлэлтийн дараах хяналтыг тавих хүрээнд:	1	-	100%



6.Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг шийдвэрлэх, хяналт тавих хүрээнд:	1	-	100%
7.Иргэний харьяаллын зарим асуудлыг шийдвэрлэх олон улсын хууль тогтоомж, хэрэглээний талаар харьцуулсан судалгаа хийх хүрээнд:	1	-	100%
8.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд	1	-	100%
9.Гадаадын иргэний хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн иргэнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд	1	-	100%
10.Гадаадын иргэний хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн иргэнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд:	1	-	100%
Нийт	9	1	99,0 %

Дүгнэлт: Тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 10 зорилтын хэрэгжилт **99,0** хувьтай **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэсэн үнэлгээтэй байна.

ҮР ДҮНТЭЙ ХИЙГДСЭН АЖЛУУДААС ДУРДВАЛ:

Гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах хүрээнд:

Тус байгууллага нь 2023 онд хугацаанд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн гадаадын 44831 иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 34212 иргэний визийн зөвшөөрлийг хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 10619 иргэний визийн зөвшөөрлийг боомт, орон нутаг дахь нэгжид илгээсэн байна. Хилийн боомтод 9288, төвд 204, нийт 9492 иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз олгож, 17 иргэний визэд шилжүүлэг хийсэн байна.

Гадаадын иргэний бүртгэл, хяналтыг эрхлэх хүрээнд:

Гадаадын 23555 иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 19488 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган оршин суух зөвшөөрөлтэй 12658 иргэний бүртгэлд хасалт хийсэн байна.

Гадаадын иргэнийг уригч 497 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 1439 гадаадын иргэний виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 6886 гадаадын иргэний хаягийг бүртгэж, нутаг буцсан, статус өөрчлөгдсөн 7231 иргэний бүртгэлд хасалт хийж, Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог улсын түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 4612 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан байна.

Монгол Улсад оршин суух 34992 үнэмлэхийг шинээр хэвлэж, 4664 үнэмлэхийн хүчинтэй



хугацааг сунган 275 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийсэн байна.

Гадаадын 34 иргэнд регистрийн дугаар, 2 иргэнд зорчих үнэмлэх, 2085 иргэнд цагаачийн гарах-орох мэдэгдэл олгосон байна.



Eimmigration.mn системээр 19569 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 41244 иргэний визийн зөвшөөрөл, 3314 иргэний байх хугацаа сунгалт, 7752 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 21355 иргэний оршин суух зөвшөөрлийн олголт, 6728 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 17997 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, 2293 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн оршин суух зөвшөөрөлтэй 7118 иргэний бүртгэлд хасалт хийж, 475 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 732 иргэний паспортод өөрчлөлт, 74 уригч иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн 131 иргэний хаягт өөрчлөлт, оршин суух үнэмлэх дахин авах 251 иргэн, 48 цагийн бүртгэл хийлгэх 22046 иргэн, цагаачийн гарах орох мэдэгдэл хүссэн 1755 иргэний хүсэлтийг тус тус хүлээн авч, хянан шийдвэрлэсэн байна.





Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах хүрээнд:

Лавлах утасны 1800-1882 мэдээллийн төв болон боомт, орон нутаг дахь нэгжийн зөвлөгөө, мэдээлэл хариуцсан албан хаагчид гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар 23146 иргэнд утсаар, 5272 иргэнд биечлэн, 155 иргэнд цахимаар, нийт 28573 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаласан байна. Оршин суух зөвшөөрлийн олголт, хасалт, хэлбэр болон хаягийн өөрчлөлт, байх хугацаа сунгалт, 48 цагийн бүртгэл, цагаачийн гарах орох мэдэгдэл, паспортод өөрчлөлт хийх, үнэмлэх дахин авах үйлчилгээг Eimmigration.mn системээр үзүүлж эхэлсэн, үйлчилгээ бүрд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, шаардлагатай бусад мэдээллийг тодорхой байршуулснаар иргэд тус систем болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан бие даан мэдээлэл авах сувгийн хүртээмж нэмэгдэж, ашиглалт хэвшсэнээр утсаар болон биечлэн ирж, зөвлөгөө, мэдээлэл авах тоо буурч, цаашид мөн буурах хандлагатай байна.

Монгол Улсын иргэний харьяаллын талаарх хүсэлтийг хүлээн авч, холбогдох ажиллагааг зохион байгуулах хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 удаагийн зарлигаар Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын 2 иргэн Монгол Улсын харьяат болсон. Харьяат болох хүсэлт гаргасан 16 иргэний хүсэлтийг хүлээн авч, хуульд заасан шаардлага хангаагүй 4 иргэний хүсэлтийг түдгэлзүүллээ. Холбогдох байгууллагаас 13 иргэний хүсэлт, баримт бичигт санал авч, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар (ЗГХЭГ)-т 8 иргэний хүсэлтийг хүргүүлж, 9 иргэний хүсэлтийг Ерөнхийлөгчийн Тамгын Газар (ЕТГ)-т уламжилсан байна.

Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 172 иргэний хүсэлтийг хүлээн авч, 182 иргэний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал аван 181 иргэний хүсэлтийг ЗГХЭГ-т хүргүүлж, 165 иргэний хүсэлтийг ЕТГ-т уламжилсан. Ерөнхийлөгчийн 9 удаагийн зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан 262 иргэний мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэж, баяжилт хийжээ.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 13 иргэний хүсэлтийг хүлээн авч, 11 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал аван 10 иргэний хүсэлтийг Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газарт 10 иргэний хүсэлтийг ЕТГ-т уламжилсан байна.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай гадаадын иргэний хүсэлтийг шийдвэрлэх, үрчлэлтийн дараах хяналтыг тавих хүрээнд:

Байгууллагын дэргэдэх “Мэргэжлийн зөвлөл”-ийн 10 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар Монгол Улсын харьяат 2 хүүхдийг Румын Улсын иргэн, гэр бүлд, 1 хүүхдийг Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэн, гэр бүлд үрчлүүлэхээр шийдвэрлэн байгууллагын даргын А/377 дугаар тушаалаар баталж, “Үрчлэлтийн дараа хяналт тавих 3 талт гэрээ”-г байгуулсан.



12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 277 Монгол хүүхдийг үрчлүүлээд байна.

Бүгд Найрамдах Итали Улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн 4, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэн, гэр бүлд үрчлэгдсэн 9, нийт 13 хүүхдийн өсөлт хөгжилтийн талаарх тайлан хүлээн авч, “Гадаад улсын иргэнд үрчлүүлсэн Монгол Улсын харьяат хүүхдийн мэдээллийн сан”-д бүртгэсэн. Тайлан ирүүлээгүй, 27 үрчлэгдсэн хүүхдийн харьяалах улсад суугаа 8 дипломат төлөөлөгчийн газарт Гадаад харилцааны яамны Консулын газраар дамжуулан хүүхдийн өсөлт хөгжилтийн талаарх тайлан ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн байна.

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг шийдвэрлэх, хяналт тавих хүрээнд:

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газраас үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой нийт 42 хүсэлтийг хүлээн авч, санал авахаар холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Байгууллагын дэргэдэх “Мэргэжлийн зөвлөл”-ийн 5 удаагийн хурлаар олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 4 байгууллагад шинээр олгож, 41 байгууллагын зөвшөөрлийг сунгасан байна.

2023 онд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон байгууллага байхгүй байна.

2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг 71 төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газраас хүлээн авч, 14 байгууллагад тодорхойлолт олгосон байна.

Монгол Улсад нийт 82 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

Иргэний харьяаллын зарим асуудлыг шийдвэрлэх олон улсын хууль тогтоомж, хэрэглээний талаар харьцуулсан судалгаа хийх хүрээнд:

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын туршлагыг судалж “Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох нь” сэдвээр онол, хэрэглээний талаар 25 хуудас бүхий харьцуулсан судалгаа, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Австралийн Холбооны Улс болон бусад улсын хууль тогтоомжийг судалж, “Улс хооронд хүүхэд үрчлэлтийн талаарх өнөөгийн нөхцөл байдлыг зарим улсын хууль тогтоомжтой харьцуулах нь” сэдвээр 15 хуудас бүхий судалгааг хийсэн байна.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх,



таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт 37, төлөвлөгөөт бус 482, нийт 519 хяналт шалгалтыг зохион байгуулж, хяналт шалгалтаар 1013 аж ахуйн нэгж байгууллага, 6640 гадаадын иргэний баримт бичгийг шалгаж, 218 зөрчлийг илрүүлэн 54 зөрчилд албадан гаргах, 131 зөрчилд торгох шийтгэл оногдуулан 25 албан шаардлага өгч, 4 зөрчилд оршин суух зөвшөөрлийг цуцалж, 20 гарах сануулга өгсөн байна.

Гадаадын иргэний хяналтыг сайжруулж, хууль зөрчсөн иргэнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд:

Хууль тогтоомж зөрчсөн гадаадын 24 улсын 395 иргэнийг байгууллагын даргын 191 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргаж, 9 улсын 47 иргэнийг байгууллагын даргын 35 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан шийдвэрийг хүчингүй болгон 5 улсын 8 иргэний албадан гаргасан хугацааг сунгасан байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 8 улсын 59 иргэнийг 52 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн байна.:

Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн 7 улсын 51 иргэний хилээр гарах эрхийг 45 удаагийн тушаалаар сэргээсэн байна.

Дээд шатны байгууллагыг гадаадын иргэний зөрчлийн мэдээллээр хангах хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг нийт 25 удаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэдийн мэдээллийг нийт 15 удаа Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн байна. Мөн 2023 оны 03 дугаар сараас 09 дүгээр сар хүртэл өдөр бүрийн 16:00 цагт гадаадын иргэний зөрчлийн шуурхай мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэн ажилласан байна.

Хоёр.ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУДАД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

2.1. Гадаадын иргэн, харьяатын хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн хүрээнд байгууллагын төлөвлөгөөнд тусгадсан томоохон зорилтуудыг жилийн эцсийн байдлаар үнэлэхэд:

Хүснэгт-4

ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД	Үүнээс (хувиар)		Хувь
	100	90	
<i>1.Гадаад харилцааг өргөжүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд:</i>	1	-	100%
<i>2.Гадаад хамтын ажиллагааны хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд:</i>	-	1	90%
<i>3.Гадаад сургалтад албан хаагчдыг оролцуулах, туршлага солилцох хүрээнд</i>	1	-	100%



4.Монгол Улсын хууль тогтоомжид санал хүргүүлэх, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох хүрээнд:	1	-	100%
5.Монгол Улсын иргэний харьяаллын хууль тогтоомж, дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлуулах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлэх хүрээнд	-	1	90%
6.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах хүрээнд	-	1	90%
7.Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах хүрээнд	-	1	90%
8.Жендэрийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах хүрээнд:	1	-	100%
9.Хүүхдийн эрхийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд:	1	-	100%
10.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх хүрээнд:	1	-	100%
11.Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх хүрээнд:	1	-	100%
12.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх хүрээнд:	1	-	100%
13.2021-2022 оны архивын байнга хадгалах зарим нэрийн баримтыг цахим программд холбох хүрээнд:	-	1	90%
14.Худалдан авах ажиллагааны 2023 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнах хүрээнд:	-	1	90%
Нийт	8	6	95.7%

Дүгнэлт: Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 14 зорилтын хэрэгжилт **95.7** хувьтай **“Үр дүнтэй”** гэсэн үнэлгээтэй байна.

ҮР ДҮНТЭЙ ХИЙГДСЭН АЖЛУУДААС ДУРДВАЛ:

Гадаад харилцааг өргөжүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд:

Бүгд Найрамдах Солонгос Улсын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвтэй “Харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 06 дугаар сарын 13-ны өдөр, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын “Мэдээлэл солилцоо болон цагаачлалын менежментийн тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 11 дүгээр сарын 02-ны өдөр тус тус байгуулсан байна.

Түүнчлэн Бүгд Найрамдах Чех Улсын Дотоод хэргийн яамны харьяа Гадаадын иргэний хяналтын газар болон Орогнол, шилжилт хөдөлгөөний бодлогын газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний цагаачлалын удирдах газартай байгуулах “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төслийг хүргүүлсэн байна.



Тус байгууллага нь гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайд, консул, олон улсын байгууллагын холбогдох албан тушаалтантай нийт 35 удаагийн албан уулзалт хийж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Бээжин хотод суугаа Элчин сайдын яамны Холбооны цагдаагийн газрын виз, паспортын асуудал эрхэлсэн мэргэжилтнүүд, Бүгд Найрамдах Солонгос Улсын Шилжилт хөдөлгөөний судалгаа, сургалтын төвийн төлөөлөгчид, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яамны дэд сайд болон Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа Үндэсний цагаачлалын удирдах газрын төлөөлөгчдийг Монгол Улсад хүлээн авах айлчлалыг зохион байгуулсан байна.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд:

Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-тай хамтран “Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийг 2023 оноос 2025 он дуустал буюу 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх ба төслийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам болон байгууллагын 15 албан хаагчыг чадавх бэхжүүлэх сургалтад хамруулаа.

Гадаад сургалтад албан хаагчдыг оролцуулах, туршлага солилцох хүрээнд:

Тайлант хугацаанд гадаад улсад зохион байгуулагдсан 7 удаагийн сургалтад 57 албан хаагч, 6 удаагийн олон улсын хурал, зөвлөгөөнд 9 албан хаагч, 7 удаагийн айлчлалд 22 албан хаагч, нийт 88 албан хаагчийг хамруулж, мэдлэг, чадавхыг дээшлүүлэн олон улсын туршлагаас суралцах боломж, нөхцөлөөр хангасан байна.

Монгол Улсын хууль тогтоомжид санал хүргүүлэх, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох хүрээнд:

Улсын Их Хурлаас батлах 4 хуулийн төсөл, 1 тогтоолын төсөл, Засгийн газраас батлах 3 тогтоолын төсөл, салбарын сайдын тушаалаар батлах 1 журмын төсөл, бусад 2 эрх зүйн актын төсөл, нийт 11 эрх зүйн баримт бичигт тус тус санал боловсруулан хүргүүлж, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах 6 эрх зүйн баримт бичгийг шинэчлэн баталсан байна. Үүнд:

Хуулийн төсөл:

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 01 дүгээр сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн баталснаар Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын жагсаалтад багтаж, албан хаагч нь төрийн тусгай албан хаагчийн ангилалд хамрагдсан байна.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, “Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөлд “Монгол



Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль” практикт хэрэгжихгүй байгаа шалтгаан, нөхцөлийн талаар судалж боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

Мөн “Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль”-ийн төсөлд санал хүргүүлэв.

УИХ-аас батлах тогтоолын төсөл:

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн шинэчлэн боловсруулсан төсөлд санал хүргүүлсэн ба Монгол Улсын Их Хурлын 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

Засгийн газрын тогтоолын төсөл:

“Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зохицуулалтын талаар” Засгийн газрын тогтоолын төсөлд холбогдох санал, Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмын төсөл”-д төрийн байгууллага, яамдаас ирүүлсэн саналын нэгтгэлийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хянаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яаманд “Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчийн ангилал, зэрэглэл, түүний нэмэгдлийг батлах Засгийн газрын тогтоолын төсөл”-ийн талаарх танилцуулга хүргүүлсэн..

Монгол Улсын иргэдийг Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих визийн нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр боловсруулсан Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 05 дугаар сарын 03-ны өдрийн 166 дугаар тогтоолоор батлуулсан байна.

Сайдын тушаал:

“Кибер халдлага, зөрчлийн мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам”-ын төсөлд санал бэлтэн Цахим хөгжил, харилцаа, холбооны яаманд хүргүүлсэн байна.

Бусад эрх зүйн акт:

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг дагалдан гарах захиргааны эрх зүйн актын төсөлд санал;

“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн хэрэгжилттэй холбогдуулан “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-ний төслийг шинэчлэн боловсруулсан.

“Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар сарын 03-ны өдрийн А/33 дугаар тушаал;

“Цахим баримт бүрдүүлэх, хөтлөх, архивд шилжүүлэх журам батлах тухай” 03 дугаар сарын 13-ны өдрийн А/65 дугаар тушаал;

“Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих, тайлан гаргах заавар батлах тухай” 05 дугаар сарын 11-ний өдрийн А/147 дугаар тушаалыг тус тус баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ын



хэрэгжилттэй холбогдуулан байгууллагын даргын 2023 оны А/204 дүгээр тушаалаар байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан. Мөн 2021 оны “Өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай” А/107, “Техникийн комиссын ажиллах журам батлах тухай” А/108 дугаар тушаал, 2022 оны “Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” А/99 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Байгууллагын даргын 2012 оны “Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх комиссын бүрэлдэхүүн”-ийг баталсан А/619 дүгээр тушаалыг 05 дугаар сарын 22-ны өдрийн А/161 дүгээр тушаалаар хүчингүй болгож, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан дахь бүртгэлээс хасуулан мөн өдрийн А/162 дугаар тушаалаар комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

-Визийн мэдүүлгийн хуудсыг QR хэлбэрт шилжүүлсэнтэй холбогдуулан байгууллагын даргын 08 дугаар сарын 24-ний өдрийн “Визийн мэдүүлгийн хуудсыг цахимаар мэдүүлэх тухай” А/283 дугаар тушаалыг баталж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Монгол Улсын иргэний харьяаллын хууль тогтоомж, дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлуулах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлэх хүрээнд

Харьяатын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор “Дэлхийн улс орнуудын давхар харьяаллын талаар баримталж буй бодлого” сэдэвт судалгааг хийсэн байна.

Мөн “Гэр бүлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг боловсруулан “Гэр бүлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх хуралдаанд хүүхэд үрчлэлт, төрийн бус байгууллага хариуцсан мэргэжилтэн оролцлоо.

“Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-д нэмэлт өөрчлөлтийн санал хүргүүлэх хүрээнд:

“Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, түүнээс чөлөөлөх, Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-д оруулах нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулж, танилцуулгын хамт Хууль зүй, дотоод яаманд хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах хүрээнд:

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” болон “Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус батлан байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.



“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем”-д үүсгэсэн мэдүүлэг гаргагч нийт 182 албан тушаалтны 2022 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд бүрэн шинэчлэн гаргуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 63 албан хаагч, иргэний материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргаж хэвшлээ. Үүнд:

- Төрийн бусад байгууллагаас шилжин ажиллах-6
- Нэгж хооронд шилжин ажиллах-22
- Нэгж хооронд сэлгэн ажиллах-1
- Төрийн бусад байгууллагаас сэлгэн ажиллах-1
- Төрийн бусад байгууллагад сэлгэн ажиллуулах-1
- Шинээр томилогдох-18
- Дэвшүүлэн томилох-2
- Албан тушаал бууруулсан-2
- Түр орлон гүйцэтгэгчээр томилох-9
- Жинхэлж томилогдох-1

Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах хүрээнд:

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн хурлаар Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан



Байгууллагын даргын тушаалаар төв орон нутаг дахь нэгжийн нийт 252 албан хаагчийн ангилал, зэрэглэл, цалин, нэмэгдэл, төрийн захиргааны 174 албан хаагчдын албан тушаалын цалин, төрийн үйлчилгээний 79 албан хаагчдын албан тушаалын ангилал, цалингийн доод хэмжээг тус тус шинэчлэн баталлаа.

Мөн ажлын цагийн горимд өөрчлөлт оруулан 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлигаар байгууллагын удирдлагад тэргүүн түшмэлийн дөтгөөр, Монгол Улсын Ерөнхий сайдын 410 дугаар захирамжаар 1 газрын даргад эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэрэг дэв шинээр, 2 газрын даргад дэд зэрэг дэв олгуулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/186 дугаар тушаалаар 2 албан хаагчид ахлах түшмэлийн, 14 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр, 48 албан хаагчийн зэрэг дэв ахиулан олгуулахаар шийдвэрлүүлэн 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс зэрэг дэвийн нэмэгдлийг олгож эхэлсэн.

Монгол Улсын Их Хурлын хуралдаанаар баталсан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 41 дүгээр зүйлийн 41.14, 41.18 дахь хэсэгт Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийг хэмжээг Засгийн газар тогтоохоор заасан. Хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд дагалдан гарах журмын төслийг боловсруулж, байгууллагын даргын А/06 дугаар тушаалаар баталж, тогтоолын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн..



Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах хүрээнд:

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн хурлаар 2023 оны сургалтын төлөвлөгөөг 6 дэд бүлгийн 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Дотоод сургалтын талаар:

Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 5, мэргэшүүлэх сургалтад 4, дунд хугацааны давтан сургалтад 4, ахлах түшмэлийн багц сургалтад 5, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, нийт 20 албан хаагчийг суралцуулсан байсан.

Байгууллагаас эрх зүйн шинэтгэлийг таниулан хувь хүний хөгжлийг дэмжих, албан хаагчийн чадавхыг дээшлүүлж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан 39 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээ, 1 удаагийн “Нэгдсэн сургалт, зөвлөгөөн”-д давхардсан тоогоор 2060 албан хаагч, бусад байгууллагаас зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 153 албан хаагчийг тус тус хамруулсан байна.



Түүнчлэн байгууллагын даргын тушаалаар албан хаагчдыг ажлын байранд сургах, чадавхжуулах зорилгоор боомт, орон нутаг дахь нэгжийн давхардсан тоогоор 32 албан хаагчийг Виз, зөвшөөрлийн газарт сэлгэн ажиллуулж, боомт, орон нутгийн албан хаагчдыг чадавхжуулах, ажлын ачааллыг бууруулах зорилгоор төвийн нэгжээс 5 албан хаагчийг сэлгэн ажиллуулсан байна.

Гадаад сургалтын талаар:



Гадаад улсад зохион байгуулагдсан 7 удаагийн сургалтад 57 албан хаагчийг хамруулсан байна. Үүнд:

1. БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа Цагдаагийн дээд сургуулиас зохион байгуулсан “Монгол Улсын хил хамгаалалтын ажил үйлийн семинар” сэдэвт 14 хоногийн сургалтад 10 албан хаагч;

2. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтад 15 албан хаагч;

3. БНХАУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулсан “Хилээр орох, гарах ба цагаачлалын менежментийн семинар” сэдэвт 14 хоногийн сургалтад 20 албан хаагч;

4. Тайванийн Дотоод хэргийн яамны харьяа Цагаачлалын газраас зохион байгуулсан “2023 оны цагаачлалын албаны ажилтнуудын жишиг сургалт, семинар”-т 2 албан хаагч;

5. Тайванийн Минчуаны их сургуульд хятад хэлний мэдлэг дээшлүүлэх 3 сарын сургалтад 3 албан хаагч;

6. Унгар улсын Будапешт хотноо зохион байгуулагдсан “Гадаад иргэдийн бодлого зохицуулах ерөнхий газрын ерөнхий үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах” 14 хоногийн сургалтад 3 албан хаагч;

7. Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо зохион байгуулагдсан “Баримт бичгийн хуурмаглалтай тэмцэх, туршлага судлах” сургалтад 4 албан хаагчийг тус тус хамруулсан байна.

Жендэрийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах хүрээнд:

Байгууллагын дэргэдэх Жендэрийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, жендэрийн эрхийг хангах хүрээнд дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

Жендэрийн хэвшмэл ойлголтын талаарх цахим санал асуулгыг төв, орон нутаг дахь нэгжийн 146 албан хаагчдын дунд зохион байгуулж, судалгааны дүнд үндэслэн албан хаагчдад “Жендэрийн үндсэн ойлголт ба хэвшмэл ойлголт”, “Удирдах албан тушаалтны харилцаа, хандлага, ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь”, “Жендэрийн тухай үндсэн ойлголт, жендэрийн ялгаварлан гадуурхалт ба жендэрт суурилсан хүчирхийлэл”, “Жендэрийн тухай ойлголт”, “Жендэрийн тэгш байдлыг хангах буюу охид, эмэгтэйчүүдийг чадавхжуулах нь” сэдэвт 5 удаагийн сургалтад төв болон боомт, орон нутаг дахь нэгжийн 203 албан хаагчийг хамруулсан байна.

Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан судалгаагаар төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн 26.9 хувь нь ямар нэг байдлаар ажлын байрны бэлгийн дарамтад өртдөг дүн гарсан. Үүнтэй холбогдуулан ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, зөвлөмж мэдээллийг нийт албан хаагчдад танилцуулж, байгууллагын цахим самбарт 1 сарын хугацаанд нээлттэй байршуулсан байна.



Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд Монголын урчуудын эвлэлтэй хамтран урлагаар дамжуулан гоо зүй, уран сайхны талаарх ойлголт мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор уран зургийн үзэсгэлэнг албан хаагчдад танилцуулах арга хэмжээг зохион байгуулж 57 албан хаагчийг оролцуулсан байна.

Албан хаагчдын харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр талархлын захиа илгээх, бэлэг солилцох үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 90 албан хаагчийг хамруулсан байна.

Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх санал асуулгыг төв, орон нутаг дахь нэгжийн 180 албан хаагчаас авч, дүнд үндэслэн холбогдох зөвлөмжийг боловсруулж, нийт албан хаагчдад танилцуулсан байна.

Ажлын орчин нөхцөл, хангамжийг хүйсийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийсэн тайлан болон үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцууллаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүрээнд:

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-ийн дарга баталж, хүүхэд хамгааллын чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор албан хаагчдын дунд зохион байгуулсан цахим санал асуулгын дүнд үндэслэн байгууллагын даргын тушаалаар төв байгууллагын албан хаагчдын ажлын цагийн горимд өөрчлөлт оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1, өрх толгойлсон 1, нийт 2 албан хаагчийг бага насны хүүхдээ цэцэрлэг, сургуулиас авах, хүргэх боломжоор хангах зорилгоор харьяалах нэгжийн даргын баталсан зайнаас ажиллах хуваарийг тус тус мөрдүүлж ажилласан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/110 дугаар тушаалаар баталсан албан хаагч бүр ажлын байр, гэр бүл, нийгмийн орчинд дагаж мөрдөх “Ажилтнуудын ёс зүйн дүрэм”-ийг төв, орон нутаг дахь нэгжийн нийт 260 албан хаагчдад танилцуулах ажлыг зохион байгуулсан байна.

Хүүхдэд ээлтэй байгууллага, хамт олон байх, хүүхэдтэй холбоотой аливаа зөрчлийг мэдээлэх чиг үүргийн хүрээнд хүүхдийн хөгжил, хүмүүжилд анхаарвал зохих зөвлөмж, мэдээллийг байгууллагын цахим самбарт байршуулж, нийт албан хаагчдад танилцууллаа.

Байгууллагад ажиллаж байгаад 2019-2020 онд хүнд өвчин, гэнэтийн осол гэмтлээс шалтгаалан нас барсан албан хаагчийн насанд хүрээгүй тусламж дэмжлэг үзүүлэх санаачлалыг байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-өөс гарган албан хаагчдын хандив тусламжаар нас барсан 5 албан хаагчийн 8 хүүхдэд 753,000 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Олон Улсын Хүүхдийг ивээх сантай хамтран “Хүүхдийн эрх, хамгаалал” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 29 албан хаагчийг хамруулсан байна. Сургалтын үр дүнд үндэслэн “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого”-ыг боловсруулан батлуулж, Эцэг, эхийн зөвлөлийн



нэгжийн нийт албан хаагчдад танилцуулсан байна.

Хойд бүс дэх газар 12 квадрат метр, Зүүн бүс дэх газар 10 квадрат метр хэмжээтэй хүүхдийн өрөөг номын тавиур, хүүхдийн тоглоом, иж бүрэн тавилгаар стандартын дагуу тохижуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх хүрээнд:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 26 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор төв, орон нутаг дахь нэгжийн 727 орчим албан хаагчийг хамруулсан байна. Мөн объектын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 10 заалт бүхий 01 дүгээр зөвлөмжийг төв, боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нарт хүргүүлэв.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны эхний хагас жилд гүйцэтгэсэн ажлын тайлан, Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бүс эргэлттэй тэмцэх, үндэсний хорооны 2023 оны төлөвлөгөөний биелэлт тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн ажиллаа.

Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх хүрээнд:

Тус байгууллага 2023 онд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 112 мэдээ, мэдээлэл бэлтгэж, цахим хуудаст 228 мэдээ, ярилцлага, видео, нээлттэй мэдээлэл, нийгмийн сүлжээн дэх байгууллагын цахим хуудас (facebook)-т 176 мэдээллийг тус тус байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн байна. Тогтмол мэдээлэл байршуулснаар байгууллагын нийгмийн сүлжээн дэх цахим хуудас 21074 дагагчтай болжээ.

Бэлтгэсэн мэдээллийг давхардсан тоогоор 489 хэвлэл, мэдээллийн хэрэгсэл (390 сайт, 45 сонин, 54 телевиз)-ээр сурталчилсан. Тухайлбал “ГИХГ гадаадын иргэний оршин суух үнэмлэх хэвлэх, олгох үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлнэ” мэдээллийг 25 сайт, 5 телевиз, 3 сонинд, “Цахим виз олгох улсын жагсаалт шинэчлэгдэж, 99 орны иргэдэд цахим виз олгоно” мэдээллийг 19 сайт, 3 телевиз, 2 сонинд тус тус нийтлүүлсэн байна. Мөн Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Нээлттэй хором” хэлэлцүүлэгт Виз, зөвшөөрлийн газрын дарга оролцож, хөдөлмөр эрхлэх ангиллын визтэй холбоотой мэдээлэл, “Зочны цаг” ярилцлагад Виз, зөвшөөрлийн газрын ахлах мэргэжилтэн оролцож, гадаадын иргэдийн виз, оршин суух зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл, зөрчил шалган шийдвэрлэлттэй холбоотой асуудлаар Зөрчил шалган шийдвэрлэх газрын хяналтын улсын ахлах байцаагч Ийгл телевизэд тус тус мэдээлэл бэлтгэн танилцуулсан байна. Гадаадын иргэд 13 орон бүхий бүртгэлийн дугаар (F-Register) ашиглан E-Mongolia.mn системээс үйлчилгээ авах боломж бүрдсэн талаар Гадаад харилцааны яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран зохион байгуулсан



хэвлэлийн хуралд Виз, зөвшөөрлийн газрын дарга оролцож, мэдээлэл өгснийг байгууллагын мэдээллийн сувгууд болон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх хүрээнд:

Байгууллагын хэмжээнд иргэнээс 742, албан хаагчаас 264, нийт 1006 өргөдлийг (өргөдөл 962, гомдол 44) хүлээн авч, 973 өргөдөл (өргөдөл 929, гомдол 44)-ийг шийдвэрлэсэн байна.

Хугацаа хэтрүүлсэн өргөдөлгүй, хуулийн хугацаанд буюу шийдвэрлэх шатанд 33 өргөдөл хянагдаж байна.

Нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлт 97,6 хувьтай байна.



2021-2022 оны архивын байнга хадгалах зарим нэрийн баримтыг цахим программд холбох хүрээнд:

Архивын цаасан суурьтай 2021-2022 оны байнга хадгалах 145 хадгаламжийн нэгжийн 36250 хуудас баримтыг и-архив программд 100 хувь холбож, цахим хэлбэрт шилжүүлсэн байна.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хий хүрээнд:

Бодлогын баримт бичигт 15, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 10, байгууллагын үйл ажиллагаанд 21, давхардсан тоогоор нийт 46 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн тайлан гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад албан бичгээр болон цахим системээр тайлагналаа. Үүнээс:

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын



хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ” (mojha.unelgee.gov.mn) системд байршуулж, баталгаажуулсан байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ” систем (mojha.unelgee.gov.mn)-д байршуулж, баталгаажуулсан байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Алсын хараа-2050, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тайланг, хурлын тэмдэглэлийн хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ систем (mojha.unelgee.gov.mn)-д байршуулж, баталгаажууллаа.

Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх хүрээнд:

Байгууллагын 2022 оны эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн 4 чиглэлээр хэрэгжүүлэх 11 арга хэмжээ бүхий “2023 онд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж мөрдүүлж байна.

Эрсдэлийн бүртгэлийн нэгдүгээр улирлын тайланг Төрийн мэдээллийн сүлжээ (mojha.unelgee.gov.mn)-нд байршуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар (tsevelmaa@mojha.gov.mn) хүргүүлсэн байна.

Эрсдэлийн бүртгэлийн 2023 оны жилийн эцсийн тайланг Төрийн мэдээллийн сүлжээнд байршуулсан байна.

Нийцлийн болон санхүүгийн төлөвлөгөөт аудитын хяналт, шалгалтыг зохион байгуулах хүрээнд:

Дотоод аудиторын 2023 оны төлөвлөгөөний дагуу төсөв, санхүү болон нийцлийн чиглэлээр төлөвлөгөөт 8, төлөвлөгөөт бус 1, нийт 9 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн ажлын үр дүнг тухай бүр тооцон, мэргэжил, арга зүйгээр хангаж, хяналт тавин ажилласан байна. Үүнд:

Төсөв, санхүүгийн чиглэлээр:

Байгууллагын даргын 5 удаагийн удирдамжийн дагуу Хойд бүс дэх газар, Дорноговь аймаг дахь газар, Баруун бүс дэх газар, Зүүн бүс дэх газар, Өмнөд бүс дэх газрын захиргаа болон санхүүгийн 2022 он, 2023 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, үр дүнг илтгэх хуудсаар удирдлагад тус тус танилцуулсан. Хойд бүс дэх газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнд үндэслэн “Ажлын хариуцлагыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгавар, Дорноговь аймаг дахь газар, баруун бүс дэх газарт тус тус аудитын зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөвт байгууллагуудын нэгтгэсэн тайлан балансыг нэгтгэн, санхүүгийн аудит хийлгэж, тодруулга, тайлбар гаргах хүрээнд:

Төсвийн шүүд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн



эцсийн санхүүгийн тайланг 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/360 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, холбогдох мэдээ судалгаа, шаардагдах баримт материал, нэмэлт тайлбар, тодруулгыг заасан хугацаанд гарган өгч ажилласан байна. Үндэсний аудитын газрын хяналт шалгалтаар 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “өөрчлөлтгүй” дүгнэгдэж, 6 зөвлөмж, 1 акт, 4 албан шаардлага хүлээн авсан. Өмнөх онтой харьцуулахад зөвлөмжийн тоо буурсан, актын тоо өөрчлөлтгүй, албан шаардлагын тоо өссөн үзүүлэлттэй байна.

Худалдан авах ажиллагааны 2023 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнах хүрээнд:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/132 дугаар тушаалаар шинэчлэн баталсан 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 7 төрлийн 1,300.0 сая төгрөгийн өртөг бүхий төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үнэлгээний хороо байгуулан tender.gov.mn цахим системд нээлттэй зарлаж, өдөр тутмын сонин хэвлэлээр урилга хүргүүлэн үнийн саналыг цахимаар авч, 1 арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын, 4 төсөл, арга хэмжээг харьцуулалтын, 1 арга хэмжээг шууд худалдан авалтын аргаар тус тус зохион байгуулж, 6 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан ба 1 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч санал ирүүлээгүйн улмаас тендер амжилтгүй болсон байна.

Гэрээ байгуулсан нийт 6 төсөл, арга хэмжээнээс “Нормын хувцас бэлтгэн нийлүүлэх” гэрээний биелэлт 85 хувийн гүйцэтгэлтэй байгаагаас шалтгаалан төлөвлөгөө 97.5 хувьтай хэрэгжсэн байна.

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮТЭЭМЖ, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ХИЙГДСЭН АЖЛУУДАД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

3.1. Төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх талаар хийгдсэн ажлыг жилийн эцсийн байдлаар үнэлэхэд:

Хүснэгт-13

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮТЭЭМЖ, ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХҮРЭЭНД	Үүнээс (хувиар)		Хувь
	100	90	
1.Цахим виз олгох улсын тоог нэмэгдүүлэх талаар санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх хүрээнд	1	-	100%
2.Гадаадын иргэнд Монгол Улсын цахим виз олгох үйл ажиллагааг эрхлэх хүрээнд:	1	-	100%
3.Нээлттэй мэдээллийг ил тод байлгах хүрээнд:	1	-	100%
4.Кибер аюулгүй байдлын талаар арга хэмжээ хэрэгжүүлэх, хариуцсан албан хаагчийг томилох хүрээнд	1	-	100%



5.Баруун бүс дэх газрын иргэдэд үйлчлэх албаны барилгын ажлын гүйцэтгэлийг хангуулах хүрээнд:	1	-	100%
6. Өмнөд бүс дэх газрын албаны барилгын гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүрээнд	-	1	90%
Нийт	5	1	98.3%

Дүгнэлт: Төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх талаар хийгдсэн ажлыг жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдсан 6 зорилтын хэрэгжилт **98.3** хувьтай **“Үр дүнтэй”** гэсэн үнэлгээтэй байна.

ҮР ДҮНТЭЙ ХИЙГДСЭН АЖЛУУДААС ДУРДВАЛ:

Цахим виз олгох улсын тоог нэмэгдүүлэх талаар санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх хүрээнд

Тус байгууллага нь 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс “evisa.mn” цахим системийг үйл ажиллагаанд нэвтрүүлж, 36 улсын иргэнд цахим визийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн байна.

Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоолоор Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлсөн.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас “2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын цахим виз олгох улсын жагсаалтад багтаж байсан Европ болон Австрали тивийн 34 улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлсөн байна.

Үүнтэй холбогдуулан “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn) дэх бүртгэлээс 35 улсыг хасаж, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/09, А/53 дугаар хамтарсан тушаалаар 98 улсыг цахим виз олгох улсын жагсаалтад нэмснийг уг системд бүрэн нэвтрүүлж, өнөөдрийн байдлаар нийт 99 улсын иргэнд цахим визийг олгож эхэлсэн байна.

Гадаадын иргэнд Монгол Улсын цахим виз олгох үйл ажиллагааг эрхлэх хүрээнд:

Тус байгууллага нь 2023 онд evisa.mn системээр 82 улсын 31242 иргэнд цахим виз олгож, 281 иргэнд виз олгохоос татгалзсан байна.

Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэнд цахим гарын үсэг олгох ажлын бэлтгэл хангах хүрээнд:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай “Танилт нэвтрэлтийн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Тредиум ХХК-д 09 дүгээр сарын 13-ны өдөр, Ньюкомпасскэй ХХК-д 11 дүгээр сарын 06-ны өдөр “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан гадаадын иргэний бүртгэлийн дугаар, гадаад паспортын мэдээлэлд нэвтрэх эрхийг нээн өгснөөр гадаадын иргэн цахим гарын үсэг эзэмших



нөхцөлийг бүрдүүлсэн байна



Мөн гадаадын иргэн 13 орон бүхий бүртгэлийн дугаар (F-Register) болон тоон гарын үсэг ашиглан танилт нэвтрэлтийн ДАН системд нэвтрэх хөгжүүлэлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран 11 дүгээр сарын 02-ний өдөр хийж гүйцэтгэсэн байна.

Нээлттэй мэдээллийг ил тод байлгах хүрээнд:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, байгууллагын даргын 2022 оны "Нээлттэй мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх ажлын зохион байгуулалтын тухай" А/135 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, байгууллагын чиг үүрэг, стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний талаарх 39 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээлж байна. Тайлант хугацаанд зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн 116 мэдээллийг нээлттэй байршуулсан байна.. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэлээр 94;

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын 35 мэдээлэл
- Статистикийн 12 мэдээлэл
- Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн 10 мэдээлэл
- Үйл ажиллагааны 35 мэдээлэл
- Хяналт шалгалтын 2 төлөвлөгөө

Хүний нөөцийн чиглэлээр 21;



- Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, холбогдох журмын талаар 10 мэдээлэл
- Сонгон шалгаруулалтын 5 мэдээлэл
- Салбар зөвлөлийн 2 мэдээлэл
- Сургалтын 2 төлөвлөгөө
- Ажлын байрны 1 тодорхойлолт (нэгж тус бүрээр нийт 95 ажлын байрны тодорхойлолт)
- Авлигын эсрэг үйл ажиллагааны 1 мэдээлэл

Эзэмшиж буй газрын 1 мэдээллийг тус тус байршуулсан байна.

Кибер аюулгүй байдлын талаар арга хэмжээ хэрэгжүүлэх, хариуцсан албан хаагчийг томилох хүрээнд:

Байгууллагын даргын тушаалаар кибер аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг Мэдээллийн технологийн хэлтсийн сүлжээний инженерээр хавсран гүйцэтгүүлж байна.

Мэдээллийн аюулгүй байдал, сүлжээний чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам “Систем центр” сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан сургалтад Мэдээллийн технологийн хэлтсийн 5 албан хаагч хамруулсан байна.

Кибер аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлэх 3 зорилт, 7 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний хүрээнд 92 албан хаагчийн компьютерт вирусийн эсрэг программ суулгаж, интернэт сүлжээнд холбогдсон компьютерыг бүртгэлжүүлж MAC filtering хийн сүлжээний хяналтын firewall болон netflow программын лицензийг идэвхжүүлж сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Баруун бүс дэх газрын иргэдэд үйлчлэх албаны барилгын ажлын гүйцэтгэлийг хангуулах хүрээнд:

Баруун бүс дэх газрын иргэдэд үйлчлэх албаны барилгын ажил бүрэн дуусаж, Ховд аймгийн Засаг даргын 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/699 дүгээр захирамжаар байгуулагдсан “Улсын комисс”-ын ББКД-84-33/23 дугаар дүгнэлтээр барилгыг 12 дугаар сарын 08-ны өдөр ашиглалтад хүлээн авсан байна.

Өмнөд бүс дэх газрын албаны барилгын гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх хүрээнд:

Барилгын ажлыг үргэлжлүүлэх асуудлаар шаардлагатай арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 95 хувьтай, чанар, стандарт, төсвийн зарцуулалтад захиалагч талаас (БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхим) явцын хяналт, аудит хийхээр шийдвэрлэн ажиллаж байна.



Дөрөв. ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

Аливаа байгууллагын үйл ажиллагааг дүгнэх тэргүүн асуудлын нэг нь байгууллагын тухай жилд тавьсан зорилгоо хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилтууд билээ. Иймд тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын бүтээмжээр тухайн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх боломжтой. Гадаадын иргэн, харьяатын газар 2023 онд хэрэгжүүлэхээр боловсруулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд баталсан байна.

Гадаадын иргэн, харьяатын газар нь 2 стратеги зорилго, 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 98.4 хувьтай “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж байна.

Хүснэгт-14

Нийт заалт	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй	Хэрэгжилтийн дундаж хувь
	100	90	70	50	30	0		
43	36	6	-	-	-	-	-	98,4%

90%- хэрэгжсэн дараах арга хэмжээнүүд байна. Үүнд:


- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны сургалтын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангах;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх;
- Худалдан авах ажиллагааны 2023 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнах;
- Нээлттэй мэдээллийг ил тод байлгах;
- Өмнөд бүс дэх газрын албаны барилгын гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээнүүд байна.



Төлөвлөгөөг зорилт тус бүрээр дүгнэвэл:

Хүснэгт-15

Зорилт	Үүнээс (хувиар)							дундаж хувь
	100	90	70	50	30	0	хб	
1.“Технологийн дэвшилд тулгуурлангадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулах	1	-	-	-	-	-	-	100%
2.Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна”	1	-	-	-	-	-	-	100%
3.Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	-	1	-	-	-	-	-	90%
4.Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх	-	1	-	-	-	-	-	90%
4	2	2	-	-	-	-	-	95,0%



Дүгнэлт: Тус байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 98.4% байгаа нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу Зорилтот түвшиндээ хүрсэн гэсэн үнэлгээтэй байна.

Цаашид 90 % хувь хэрэгжсэн арга хэмжээг эрчимжүүлэн Үр дүнд хүргэх нь зүйтэй.

4.2. ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН БАЙГУУЛЛАГААР ҮЙЛЧЛҮҮЛЖ БҮЙ ИРГЭД, БАЙГУУЛЛАГА

2023 онд тус газраас үйлчилгээ авсан иргэд, хэрэглэгчидтэй биечлэн уулзах болон утсаар холбогдож үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар үнэлгээ авлаа.

Гадаадын иргэн, харьяатын газраас хуулинд тусгасан төрийн үйлчилгээг үзүүлж байгаа



бөгөөд эдгээрт виз зөвшөөрөл, харьяатын чиглэл, зөрчил шалгах, хянан шийдвэрлэх зэрэг үндсэн гурван чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа юм. Тус газраас үйлчилгээ авсан иргэдийн үйлчилгээний нэр төрлийг энд авч үзье.


Та 2023 онд ямар төрлийн үйлчилгээ авсан бэ?

		Хүснэгт-16
Виз зөвшөөрлийн чиглэл-252	Харьяатын чиглэл-10	Зөрчил шалган шийдвэрлэх чиглэл-2
1. Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олголт-90,1 %(221)	1.Монгол Улсын харьяат болох—40%(4)	1. Гадаадын иргэний хяналт шалгалтын үйл ажиллагаа-100%(2)
2.Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олголт-5,8%(15)	2.Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох	
3.Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн-0.5%(1)	3.Монгол Улсын иргэний харьяатаас гарах-20%(2)	
4. Оршин суух үнэмлэх, визний сунгалт-1.6%(4)	4.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын ТББ-ын салбар төлөөлөгчийн газраар үйлчлүүлэх-40%(4)	
Дээрх дөрвөн төрлийн үйлчилгээг давхардсан хэлбэрээр авсан-6.7%(17)		

4.3 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВТАМЖ, МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭЛТ


Судалгаанд оролцсон хэрэглэгчдээс 2023 онд Гадаадын иргэн, харьяатын газраас хэдэн удаа үйлчилгээ авч байсан талаар асуухад 32.4 хувь нь дээр дурдсан үйлчилгээнээс аль нэгийг нь нэг удаа ямар нэг байдлаар авч байсан гэж хариулсан бол үлдсэн 67,6% хувь нь тухайн жилд 2 буюу түүнээс олон удаа үйлчилгээ авч байсан ажээ. Үйлчилгээ авсан хэрэглэгчдийн 40.3 хувь нь нэг удаа, 23 хувь нь 2-5 удаа, 24.2 хувь нь 6-9 хүртэл удаа авсан бол, 35,5 хувь нь арваас дээш удаа үйлчилгээ авсан гэж хариулжээ. Үүнээс үзэхэд тухайн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн хувьд ГИХГ-аас хуулинд тусгасан чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээг үнэлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

Байгууллагаас үйлчилгээ авсан давтамж



Тус газраас үйлчилгээ авсан давтамжийг авч үзэхэд жилд 10-аас дээш буюу 20 удаа үйлчилгээ авсан-13, 30 удаа үйлчилгээ авсан-10, 50 ба түүнээс дээш удаа үйлчилгээ авсан 11 хэрэглэгч байлаа. Статистик дүн мэдээллээс үзэхэд² тухайн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо хэмжээ сүүлийн хоёр жилд цар тахлын улмаас багасчт байсан бол 2022 онд 4465 2023 онд 9492 болж 112 хувь өссөн үзүүлэлттэй байна. Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдээс та үйлчилгээ авахын тулд чухам хэдэн төрлийн материал бүрдүүлсэн бэ? гэсэн асуултад дараах хариултыг өгсөн байна.

Үйлчилгээ авахын тулд бүрдүүлсэн материалын тоо






Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн зүгээс холбогдох үйлчилгээг авахын тулд 3-5 хүртэл материал бүрдүүлсэн гэж 50 хувь, 6-8 хүртэл материал бүрдүүлсэн гэж 20 хувь, 10 ба түүнээс дээш материал бүрдүүлсэн гэж 10 хувь гэж тус тус хариулжээ. Үйлчилгээ авахдаа 3 хүртэл материал бүрдүүлсэн иргэн, байгууллага 20 хувийг эзэлж байна.

Хэрэглэгчийн хувьд үйлчилгээг нэг дороос авах болон үйлчилгээг нэг дор байрладаг газар буюу нэг цэгээс үзүүлж байгаа нь иргэдэд илүү эерэг ханддаг төрүүлж байна.

Материал тус бүрийг хэрхэн бүрдүүлсэн талаарх хэрэглэгчийн санал



Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдээс та үйлчилгээг авахын тулд нэг мэргэжилтэнд олон дахин хандах тохиолдолд гарсан эсэх талаар асуухад үгүй гэсэн хариулт давамгайлж байна. Хэрэглэгчдийн 96.5 хувь нь үйлчилгээ авахдаа мэргэжилтэнд нэг удаа хандсанаар асуудлаа шийдвэрлэсэн байна.

4.4. Виз зөвшөөрлийн чиглэлийн үнэлгээ

Хүснэгт-17

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Виз зөвшөөрлийн чиглэл				
		Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олголт	Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олголт	Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн	Оршин суух үнэмлэх, визний сунгалт	Нийт
1.	Үйлчилгээний шуурхай байдал түргэн	5.00	4.50	5.00	4.1	4.31



2.	Үйлчилгээний ажилтнууд асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээдэг байдал	4.40	4.50	5.00	4.1	4.31
3	Үйлчилгээний талаар хариу мэдээлдэг байдал	4.32	4.00	5.00	4.00	4.35
4	Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал	4.30	4.20	5.00	4.00	4.40
5	Ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байдал	4.40	4.10	5.00	4.0	4.29
6	Ажилтнуудын тоо хүрэлцээтэй байдал	4.29	4.43	5.00	4.1	4.35
7	Санал, гомдол илэрхийлэх боломжтой байдал	4.40	4.27	5.00	4.7	4.30
8	Санал гомдлын дагуу арга хэмжээ авдаг байдал	4.30	4.50	5.00	4.2	4.90
	Нийт үнэлгээ	4.80(96.0)	4.79(90)	5.00(100.0)	4.1(80.0)	4.89(90)

Хэрэглэгчдийн хувьд Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олголтыг 90%-тай үнэлсэн ба Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олголтын үйлчилгээг 80%-тай үнэлжээ. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүнд үзүүлэх үйлчилгээг ихээхэн өндөр буюу 100.0 хувь гэж үнэлсэн бол оршин суух үнэмлэх, визний сунгалт хамгийн бага буюу 90%-тай үнэлэгджээ. Эдгээр бүх үнэлгээг нэгтгэн авч үзэхэд 90 хувьтай үнэлэгдсэн байна,

4.5. Харьяатын чиглэлийн үнэлгээ

Хүснэгт-18

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Харьяатын чиглэл			Нийт
		Монгол улсын харьяат болох	Монгол Улсын иргэний харьяатаас гарах	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газраар үйлчлүүлэх	
1.	Үйлчилгээний түргэн шуурхай байдал	4.50	5.00	4.00	4.17
2.	Үйлчилгээний ажилтнууд асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээдэг байдал	4.00	5.00	4.25	4.42
3	Үйлчилгээний талаар хариу мэдээлдэг байдал	4.00	5.00	4.25	4.42



4	Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал	4.00	5.00	4.00	4.33
5	Ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байдал	4.00	5.00	4.00	4.33
6	Ажилтнуудын тоо хүрэлцээтэй байдал	4.00	4.00	4.75	4.58
7	Санал, гомдол илэрхийлэх боломжтой байдал	4.00	4.50	4.00	4.17
8	Санал гомдлын дагуу арга хэмжээ авдаг байдал	4.00	4.50	4.00	4.17
Нэгдсэн үнэлгээ		4.0(80.0)	4.70(92.6)	4.75(85.1)	4.80(91.0)

Хэрэглэгчдийн хувьд Монгол Улсын харьяат болох үйлчилгээг **4.0 БУЮУ 80%**, Монгол Улсын иргэний харьяатаас гарах үйлчилгээг **4.70 БУЮУ 92.6%**, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газраар үйлчлүүлэх үйлчилгээг **-4.75 БУЮУ 85.1%**-тай түс түс үнэлсэн байна. Эдгээр үнэлгээний нийлбэрийн дунджийг авч үзэхэд 4.8 буюу 91.0%-тай үнэлэгджээ.

ГИХГ-ын гуравдахь үндсэн чиглэл бол зөрчил шалган шийдвэрлэх чиглэл болно. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр үйлчилгээ авсан хэрэглэгчийн хувьд 4.68 буюу 93.6%-ийн үнэлгээг өгсөн байна.

4.6. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлийн үнэлгээ

Хүснэгт-19

	Үзүүлэлтүүд	Зөрчил шалган шийдвэрлэх чиглэл	
		Гадаадын иргэний	нийт
1.	Үйлчилгээний түргэн шуурхай байдал	4.50	4.50
2.	Үйлчилгээний ажилтнууд асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээдэг байдал	5.00	5.00
3	Үйлчилгээний талаар хариу мэдээлдэг байдал	4.50	4.50
4	Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал	5.00	5.00
5	Ямар материал бүрдүүлэх нь ойлгомжтой байдал	5.00	5.00
6	Ажилтнуудын тоо хүрэлцээтэй байдал	4.50	4.50
7	Санал, гомдол илэрхийлэх боломжтой байдал	4.50	4.50
8	Санал гомдлын дагуу арга хэмжээ авдаг байдал	4.50	4.50
Нэгдсэн үнэлгээ		4.89 (93.6%)	

4.7. Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчдын 44% нь эмэгтэй, 56% эрэгтэй байсан бөгөөд насны ангиллаар авч үзвэл 34% нь 18-25 насны, 24% нь 26-35 насны, 21% нь 36-45 насны, 21% нь 46-аас дээш насны хэрэглэгчид байна. Боловсролын түвшингээр авч үзвэл 2% нь бага болон боловсролгүй, 4% нь бүрэн бус дунд, 37% нь бүрэн дунд, 58% нь дээд



боловсролтой байна. Судалгаанд оролцогчдын 49% нь төрийн байгууллагад ажилладаг, 16% нь оюутан, 10% нь хувийн хэвшил, 10% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 10% нь ажилгүй, 6% нь ТББ/ОУБ-д ажилладаг иргэд байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын бодлого үйл ажиллагаа, чиг үүрэг, гүйцэтгэл, хэрэгжилтийн үнэлгээ, үр дүнг 1-5 (1 бол Маш муу, 5 бол Маш сайн) оноогоор үнэлж, дундаж үзүүлэлтийг 5 байна гэж тооцсон.

Иргэдээс авсан судалгааны дүнг харвал үүргийн хэрэгжилтийн үр дүнд өгсөн үнэлгээ өмнөх жилүүдээс өссөн дүнтэй байна. Тухайлбал тус байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт 3,9-аас 4,6 үйлчилгээний түргэн шуурхай байдлын дундаж үзүүлэлт 4,8-аас 5,0 хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 4,8-5,0 болж тус тус өссөн дүн гарлаа.


Харин **Гадаадын иргэн, харьяатын газрын** талаар төрийн албан хаагчдын зүгээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ иргэдээс өндөр байгаа нь салбарын мэдээлэлд илүү, ойр байдагтай холбон авч үзэж болох юм.

4.7. Тус байгууллагын талаарх иргэдийн мэдлэг, сэтгэл ханамж, үйлчилгээний түргэн шуурхай байдал, хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийг харуулбал

Хүснэгт-20

	2021	2023
1. Байгууллагын талаарх иргэдийн мэдлэг, сэтгэл ханамж,	2.9	4.5
2. Үйлчилгээний түргэн шуурхай байдлын дундаж үзүүлэлт	3.8	4.9
3. Хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт	3,0	5.0

Үзүүлбэл:





а. Ерөнхий сэтгэл ханамж

Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн үйл ажиллагаа, мэдээлэл, шударга байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 5 бол маш сайн) үнэлүүлсэн.

Гадаадын иргэн, харьяатын байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаар судалгаанд хамрагдсан иргэд байгууллагын талаар сайн мэддэг, ямар нэгэн байдлаар үйлчилгээ авдаг талаар дэлгэрэнгүй ярьж байна. Үндсэн үйл ажиллагаа, үүргийн талаар мэдэж байгаа иргэдийн сэтгэл ханамжтай байдлын өндөр байна. Аливаа төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд сэтгэл хангалуун биш, төрд итгэх итгэл суларсан нь байдаг хэдий ч Гадаадын иргэн харьяатын байгууллагын талаар иргэд сайн үнэлгээтэй байна.

Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн өссөн үзүүлэлттэй гарч байгаа “Мэдэхгүй” гэх хариулт өмнөх онд иргэдийн 8-11%-ийг эзэлж байсан бол 2023 онд 6-7% болж буурсан эерэг үзүүлэлт гарав.



Энэ хүрээнд тус байгууллагын үүргүүдийг иргэд 2,4-2,8 оноогоор үнэлсэн бол бусад байгууллагын албан хаагчид болон хуульчид иргэдээс арай илүүгээр буюу 2,8-2,9 оноогоор үнэлжээ. Үзүүлэлт тус бүрээр харвал:

1. Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны залгамж холбоог иргэд 2,5,
2. Төрийн албан хаагчид, хуульчид 2,8
3. Ирсэн санал гомдолд хариу өгөх байдалд иргэд 2,7, ТАХ, хуульчид 2,9
4. Ажилтан албан хаагчдын харилцаа хандлагад иргэд 2,7, ТАХ, хуульчид 2,9
5. Үйл ажиллагааны шуурхай байдалд иргэд 2,6, ТАХ, хуульчид 2,8
6. Авлигаас ангид шударга ажиллаж буйд иргэд 2,4, ТАХ, хуульчид 2,8
7. Үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ техник технологийн дэвшил ашиглах байдалд иргэд 2,8, ТАХ, хуульчид 2,9
8. Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох хүмүүст мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх байдалд иргэд 2,7, ТАХ, хуульчид 2,8
9. Хяналт үнэлгээ хийх байдалд иргэд 2,6, ТАХ, хуульчид 2,9 оноо өгсөн байна.

10. Авлигаас ангид, шударга ажиллаж байгаа (2.4), байгууллагын үйл ажиллагааны залгамж холбооны (2.5) үнэлж, техник технологийн дэвшлийг ашиглах байдалд иргэд, төрийн албан хаагч, хуульчид өндөр үнэлгээ өгсөн байна.



		Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Нийт
Чанар	Үйлчилгээний чанар	7%	13%	38%	39%	4%	100%
	Байгууллагын албан хаагчид асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээддэг байдал	10%	17%	40%	29%	4%	100%
	Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, мэдлэг	9%	15%	36%	34%	5%	100%
	Хариу мэдээлдэг байдал	13%	18%	37%	24%	8%	100%
	Санал, гомдол илэрхийлэх боломж нээлттэй байдал	11%	21%	34%	28%	6%	100%
Хүртээмж	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа хүртээмж	6%	12%	45%	33%	4%	100%
	Үйлчилгээний ачааллын хэвийн байдал	6%	13%	45%	32%	4%	100%
	[Үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх талаар энгийн, ойлгомжтой байдал	5%	18%	37%	34%	6%	100%
	Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод байдал / самбар гэх мэт/	6%	18%	42%	28%	5%	100%
	Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг авах боломжтой байдал	6%	16%	41%	32%	5%	100%
Харилцаа, ёс зүй	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа алба хаагчийн харилцаа, хандлага	6%	15%	36%	35%	8%	100%
	Ажилтнууд надад туслахад бэлэн байдаг/хандлага/	8%	14%	39%	32%	7%	100%
	Ажилтнуудын эелдэг таатай харилцаа	8%	13%	39%	33%	8%	100%
	Ажилтнууд бүх үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харилцах байдал	8%	15%	38%	32%	6%	100%
	Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал	8%	10%	43%	31%	8%	100%
	Ажилтнуудын цаг баримтлах, ашиглах байдал	8%	16%	37%	31%	9%	100%
	Шударга байдал /гар харах гэх мэт/	7%	13%	40%	32%	9%	100%
Орчин нөхцөл	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа орчин	3%	12%	43%	36%	6%	100%
	Байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээ харагдахуйц ойлгомжтой байдал	3%	13%	44%	33%	6%	100%
	Үйлчилгээний төвийн доторх үзгэн бал, маягт гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээ	3%	16%	43%	32%	7%	100%
	Хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмж	4%	17%	41%	31%	7%	100%
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал	12%	26%	34%	21%	7%	100%



Судалгаанд оролцсон иргэдээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын харилцаа, ёс зүйн байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 5 бол маш сайн) үнэлүүлж, дундаж үзүүлэлт 3 байхаар тооцож, үр дүнг дундаж үзүүлэлттэй харьцуулсан байдлаар гаргалаа.

Төрийн үйлчилгээний дурдсан 4 бүлэг асуудалд 2021 онд иргэд сэтгэл ханамжгүй буюу дунджаас доогуур гарч байсан бол 2023 оны судалгаагаар бүгд дунджаас дээш үзүүлэлттэй гарсан эерэг дүн гарлаа. Энэ нь 2023 онд хийсэн ажлын үр дүнг шууд харуулж байна.

4.8. Гадаадын иргэн, харьяатын байгууллагын үйлчлүүлсэн байдалд өгсөн үнэлгээ

Иргэд төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайнаар дүгнэсэн байна. Үйлчилгээ



авсан иргэдийн үнэлэмж өссөн боловч төрийн үйлчилгээний чанар хүртээмж, өмнөх жилтэй харьцуулахад хэр ахицтай байгааг NP Score үнэлгээний аргачлалаар тооцож үзсэн болно. Гадаадын иргэн, харьяатын байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг эерэгээр хүлээн авч байна.

2021 онд хийгдсэн судалгаатай харьцуулахад 2023 онд гарсан ахиц дэвшил нь үйл ажиллагаа, үйлчилгээ сайжирсан, тус байгууллага нь үйл ажиллагаандаа техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж байгаа, Гадаадын иргэн харьяатын байгууллагын алба хаагчдын харилцаа, хандлага сайжирсан, орчны тав тухтай байдал дээшилсэн тохилог болсон гэж иргэд үзэж байна.

4.9. ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖИЙН ҮНЭЛГЭЭ,

Хэвлэл, мэдээллийн чиглэлээр хийгдсэн ажлуудаас дурдвал:

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль дагуу Гадаадын иргэн, харьяатын байгууллагын ил тод байдлын үнэлгээг хийхэд Байгууллагын Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилсэн байх үзүүлэлтийг тайланд тусгалаа.

Хүснэгт-20

№	Байгууллага	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хувиар 2021	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хувиар 2023	Харьцуулалт
1.	Гадаадын иргэн харьяатын газар	100	100	хэвийн
	ДҮН	100	100	1,4

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, байгууллагын даргын 2022 оны "Нээлттэй мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх ажлын зохион байгуулалтын тухай" А/135 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, байгууллагын чиг үүрэг, стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний талаарх 39 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээлж байна. Тайлант хугацаанд зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн 116 мэдээллийг нээлттэй байршуулсан байна.. Үүнд:

Үйл ажиллагааны чиглэлээр 94;

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын 35 мэдээлэл
- Статистикийн 12 мэдээлэл



- Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн 10 мэдээлэл
- Үйл ажиллагааны 35 мэдээлэл
- Хяналт шалгалтын 2 төлөвлөгөө

Хүний нөөцийн чиглэлээр 21;

- Хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, холбогдох журмын талаар 10 мэдээлэл
- Сонгон шалгаруулалтын 5 мэдээлэл
- Салбар зөвлөлийн 2 мэдээлэл
- Сургалтын 2 төлөвлөгөө
- Ажлын байрны 1 тодорхойлолт (нэгж тус бүрээр нийт 95 ажлын байрны тодорхойлолт)
- Авлигын эсрэг үйл ажиллагааны 1 мэдээлэл

Эзэмшиж буй газрын 1 мэдээллийг тус тус байршуулсан байна

4.10. БАЙГУУЛЛАГЫН ШИЛЭН ДАНСНЫ ҮНЭЛГЭЭ:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу 2023 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны нэгдсэн системд Гадаадын иргэн, харьяатын газар болон түүний харьяа төсөвт 7 байгууллага, нийт 8 мэдээлэл оруулах эрх бүхий хэрэглэгчид мэдээлэл байршуулж байна.

Системд бүртгэлтэй байгууллагуудын 2023 оны шилэн дансанд оруулсан мэдээллийн хэрэгжилтийг нэгж тус бүрээр нэгтгэн харуулбал:

Хүснэгт-21.

№	Байгууллагын нэр	2023 оны жилийн эцсийн байдлаар											
		Нийт мэдээлэл	Мэдээлэл хугацаандаа оруулсан	Хугацаа хоцорсон мэдээлэл	Ил тод болоогүй /мэдээлэл оруулж	Мэдээлэл оруулах хугацаа	Мэдээлэл оруулах хугацаа болоогүй	Мэдээлэл хугацаандаа болоогүй	Мэдээлэл хоцорч	Ил тод болгосон /араас нь хугацаандаа зассан	Ил тод болгосон араас хоцорч зассан	Мэдээлэл оруулагүй	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1.	Гадаадын иргэн, харьяатын газар	175	168	3	-	-	4	-	-	-	-	-	98.2
2.	Агаарын замын боомт хариуцсан газар	175	171	-	-	-	4	-	-	-	-	-	100.0
3.	Дорноговь аймаг дахь газар	175	170	1	-	-	4	-	-	-	-	-	99.4



4.	Хойд бүс дэх газар	175	170	1	-	-	4	-	-	-	-	-	99.4
5.	Өмнөд бүс дэх газар	175	167	4	-	-	4	-	-	-	-	-	97.7
6.	Баруун бүс дэх газар	175	171	-	-	-	4	-	-	-	-	-	100.0
7.	Зүүн бүс дэх газар	175	171	-	-	-	4	-	-	-	-	-	100.0
8.	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	175	164	7	-	-	4	-	-	-	-	-	96.0
Бүгд дүн		1400	1352	16	-	-	32	-	-	-	-	-	98.8

2023 оны жилийн эцсийн байдлаар дээрх 8 нэгж 3 ангиллаар 28 төрлийн 1400 мэдээлэл байршуулдаг билээ. Үүнээс байршуулах хуулийн хугацаа болоогүй 32 мэдээлэл байна. Хуулийн хугацаа болсон 1368 мэдээлэл байршуулахаас 1352 мэдээллийг тогтоосон хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож олон нийтэд мэдээлснээр тогтоосон хугацаанд мэдээлэл байршуулах үйл ажиллагаа 98.8 хувь буюу “хангалттай” үнэлгээ авсан байна.

ДҮГНЭЛТ,ЗӨВЛӨМЖ

Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 оны “Хэрэглэгчийн үнэлгээ”-г Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилтийн байдал болон бусад төрийн байгууллагуудын зүгээс иргэд олон нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шүүрхай байдал болон дээрх асуудлуудын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг 389 иргэдээс 70 орчим асуулт бүхий анкетын санал асуулга авч, төрийн албан хаагч, удирдах ажилтан экспертүүдтэй ярилцлага хийх замаар чанарын судалгаа, Гадаадын иргэн, харьяатын газрын цахим хуудаст судалгааг хийж гүйцэтгэв.

Гадаадын иргэн, харьяатын газраар 2021 онд үйлчлүүлсэн иргэдийн 37 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан гэж хариулсан бол 2023 оны судалгаагаар 52 хувь болж өссөн байна. Үйлчилгээ авсан иргэд дээд тал нь 5 хүртэлх байгууллага дамжсан бөгөөд үйлчлүүлсэн иргэдийн 30 хувь нь нэг удаагийн хандалтаар, 39 хувь нь хоёр удаагийн хандалтаар, 26 хувь нь 3-4 удаагийн хандалтаар, 5 хувь нь 5-аас дээш удаагийн хандалтаар хүссэн үйлчилгээгээ авч дуусгасан байна.

Үйлчилгээний чанар хүртээмжийг NPPScore оноо иргэдийнх (-39%), төрийн албан хаагчид (-46%) гарсан. Энэ нь үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой хийж байгаа ажил, гаргаж байгаа шийдвэрт шүүмжлэлтэй хандаж байгааг илэрхийлж байгаа бөгөөд гарсан алдаа дутагдалд иргэдийн 39 хувь, харьяа агентлаг, байгууллагын албан хаагчдын 46 хувь нь илүүтэй ач холбогдол өгч байна.

Эдгээрийг 3 бүлэг зорилтод багцлан тус бүрээр дүгнэж үзвэл:



- **Байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ**

Гадаадын иргэн, харьяатын газар нь 2 стратеги зорилго, 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар **100%- ийн онооноос 98.4%**-ийн үнэлгээ авч байна.

- **Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйн талаарх үнэлгээ**

Судалгаанд оролцсон иргэдээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын харилцаа, ёс зүйн байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 3-аас дээш дундаж, 5 бол маш сайн)

Тус байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, харилцаа, ёс зүй, орчин нөхцөлийг үнэлүүлэхээр 18 асуулт асуухад иргэд сэтгэл ханамжтай байдал дунджаас дээгүүр буюу **5 онооноос 4.9** -ийн үнэлгээ авч байна.

- **Мэдээллийн ил тод байдал:**

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, байгууллагын даргын тушаалын хэрэгжилтийг хангаж, байгууллагын чиг үүрэг, стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний талаарх 39 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээлж байна. Тайлант хугацаанд зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн 116 мэдээллийг нээлттэй байршуулсан байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар **100%- ийн онооноос 98.8%**-ийн үнэлгээ авч байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл салбарын нийт үйл ажиллагаа болон үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ **98,4% + 4.8%+98.8 %=98.4%** болж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын байгууллагын 2023 оны хэрэглэгчийн үнэлгээг хийлээ.

Үнэлгээний нэгдсэн дүнгээр тус байгууллага нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг болон, үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын харилцаа, ёс зүйн байдал, байгууллагын ил тод байдал гэсэн 3 бүлэг зорилтын хүрээнд хийгдсэн судалгааны дүнгээр **98,4%** дүгнэгдлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2023 хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилго зорилтууд нь “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээтэй үр дүнтэй ажилласан байна.

Тухайн байгууллагын төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын харилцаа, ёс зүйн байдлыг иргэд албан хаагчид өндрөөр үнэлсэн байна.

Мөн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг ил тод байршуулах болон иргэд олон нийтэд сурталчлах ажлыг холбогдох хууль дүрмийн дагуу зохион байгуулсан байна.

Тус байгууллага нь 2023 онд томоохон ажлуудыг амжилттай хэрэгжүүлсэн байна.



Үүнд:

- Цахим үйлчилгээний шинэ системийг нэвтрүүлж, дэлхийн хаанаас ч үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн;
- Цахим үйлчилгээний шинэ систем ашиглах "Хэрэглэгчийн гарын авлага"
- Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн систем ISF.mn зэрэг томоохон ажлууд хийгдсэн байна.

ЦААШИД:

Байгууллагын 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дараахь ажлуудыг Үр дүнд бүрэн хүргэж ажиллах. Үүнд:

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- Худалдан авах ажиллагааны 2023 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тайлагнах;
- Өмнөд бүс дэх газрын албаны барилгын гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг бүрэн дуусгах.

Дээрх арга хэмжээг үр дүнд хүргэж, хэрэгжилтийг хангах нь зүйтэй.

ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

2023.12.24



